

Эмнэлгийн үнэт зүйлс:

- Шинийг бүтээгч
- Багийн хамтын ажиллагаа, нийгмийн хамгаалал
- Ёс зүйтэй эмч, мэргэжилтнүүд
- Хүндэтгэлтэй харилцаа

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

1: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг эрхэмлэн тусламж үйлчилгээг үзүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг зорих

2: Ажилтны сэтгэл ханамж, хүний нөөцийн тогтвортой байдлыг бэхжүүлэх

3: Оношилгоо, эмчилгээ, сувилгааг орчин үеийн анагаах ухааны хөгжлийн түвшинд нотолгоонд суурилан өргөжүүлэн үзүүлэх

ХОЁР. СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГО ЗОРИЛТ

1. Стратегийн зорилго

Хавдрын цогц тусламж үйлчилгээг дэвшилтэт технологид тулгуурлан үзүүлж, үйлчлүүлэгчийн амьдралын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

2. Гол зорилтууд

1. Эмнэлгийн брэнд үйлчилгээ, цөмийн оношилгоо, эмчилгээ, цацраг идэвхт эмийн үйлдвэрлэл, дурангийн төрөлжсөн мэс засал, ажилбар, судсан дотуурх оношилгоо, эмчилгээ, робот мэс засал, ухаалаг эмнэлгийн удирдлагыг хөгжүүлнэ.
2. Анагаах ухааны шинэ дэвшилтэт техник, технологи, оношилгоо, эмчилгээ, мэс засал, зохион байгуулалтыг нэвтрүүлэх, нутагшуулах.
3. Сургалтын эмнэлгийн зохион байгуулалтын загварыг тусламж үйлчилгээнд иж бүрнээр нэвтрүүлнэ.
4. Ажилчдын нийгмийн асуудал, хувь хүний хөгжлийн цогц төлөвлөлт бүхий бодлогыг хэрэгжүүлэхэд эдийн засгийн шинэ арга зүйг нэвтрүүлнэ.
5. Олон улсын магадлан итгэмжлүүлэгч байгууллагаар итгэмжлүүлнэ. (JCI, ISO)
6. Төрийн тусгай үүргийн үйлчилгээ, гадаадын иргэдийг хүлээн авах чанартай тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
7. Байгууллагын хөдөлмөрийн бүтээжийг нэмэгдүүлж ухаалаг /смарт/ эмнэлгийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

8. Ноцтой тохиолдол ба сэргийлж болох таагүй тохиолдлуудын тоог боломжит хэмжээнд бууруулах
9. Эмнэл зүй болон эмнэл зүйн бус эрсдэлийн менежментийг үйл ажиллагаанд хэвшүүлэх.
10. Үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээний чанарын бодлогыг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан төрийн байгууллагын “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А/564 дүгээр тушаалаар “Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн дүрэм, бүтцийг батлах тухай” тогтоолын дагуу мандатын шинжилгээг хийсэн.

Мандатын шинжилгээгээр Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн эрхлэх асуудал нь нийт Монгол Улсын 118 хууль, Нийтлэг мөрдөгддөг хууль 50, Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй 226 стандартаас УХТЭ-т мөрдөгдөж буй 181 стандартыг тус тус хамарч байна.

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		118
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	50
	Мөрдөгддөг стандартын тоо	226(181)
Ерөнхий чиг үүрэг-1: Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, аюулгүй байдлыг эрхэмлэсэн тусламж үйлчилгээг үзүүлж, нийгмийн эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх	Хүн амын нягтрал, газар зүйн байршил, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг эрэлт хэрэгцээнд тулгуурлан нэмэгдүүлэх	Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
	Эмнэлгийн урт хунацааны тусламж, үйлчилгээ буюу сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж,	

	үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлж, чанар хүртээмжийг нь сайжруулан, олон улсын жишигт хүргэх	
ҮЧҮ-2 Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах	JCI болон ISO Олон улсын стандартын магадлан итгэмжлэх авах ажлын төлөвлөгөө гаргаж биелэлтийг хангах	
	Үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээний чанарын бодлогыг хэрэгжүүлнэ.	
	Ноцтой тохиолдол ба сэргийлж болох таагүй тохиолдлуудын тоог боломжит хэмжээнд бууруулах	
	Эмнэл зүй болон эмнэл зүйн бус эрсдэлийн менежментийг үйл ажиллагаанд хэвшүүлэх.	
ҮЧҮ-3: Эм зүйн тусламж, үйлчилгээг олон улсын түвшинд хүргэж, импортыг орлох дотоодын эм зүйн тусламж, үйлчилгээг дэмжиж ажиллах	Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, худалдан авах ажиллагааны хууль эрх зүйн орчин, эдийн засгийн үр ашгийг сайжруулах	АШУҮИС-н Эм зүйн сургууль, Монголын эмнэлзүйн эмзүйчдийн хөгжил нийгэмлэг, Эм холбоо ТББ, Эм ханган нийлүүлэх байгууллагууд
	Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх	Компьютерийн программ хангамжийн байгууллагуудтай хамтран ажиллах
	Үндэсний эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг олон улсын түвшинд хүргэж, Амьтан, ургамал, эрдсийн гаралтай уламжлалт эм, импортыг орлох зайлшгүй шаардлагатай эмийн үйлдвэрлэл, экспортыг дэмжих	Тендерийн худалдан авалт хийхэд үндэсний үйлдвэрлэлийн багцууд бий болгож, импортыг орлох үндэсний бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэдэг.
	Олон улсын нийтлэг хэрэглэгддэг чанартай эм,	

	эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нэгдсэн худалдан авалтын тогтолцоог бий болгох	
	Эм зүйн салбарын эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх	Төрийн худалдан авах ажиллагааны газар, Үндэсний аудит болон аудиторын газрууд
ҮЧҮ 4: Төрийн тусгай үүргийнхээ хүрээнд эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бий болгох	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй болгох төсөл хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн
	Нийгмийн эрүүл мэндийг дэмжсэн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг төлөвлөж төсвийн бодлогоор дэмжүүлэх,	Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийг дэмжих сан
ҮЧҮ-5 Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах	"Эмнэлгийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах журам" мөрдлөг болгон ажиллах	ЭРҮЛЛ МЭНДИЙН ЯАМ, ЭМДЕГ
	Байгууллагын санхүүгийн удирдлагыг үр ашигтай хэрэгжүүлж өр авлагын хэмжээг бууруулан ажиллана	